



88 Page

Иосеф2

-Joseph2-

- Тайлбарлагч** Египетийн сайд болсон Иосеф хааны дараа орох эрх мэдэлтэй хүн болжээ. Иосефыг сайд болсон эхний долоон жил нь өнтэй сайхан жил болсон бөгөөд ургац арвин, хүns элбэг дүүрэн байв. "Ургац, үр тариаг бүгдийг нь агуулахад хураагаарай"
- Иосеф**
- Тайлбарлагч** Египетийн түшмэдүүд ийм өнтэй сайхан жилүүд болж байхад яагаад ингэж хүns ногоогоо хадгалаад байгааг ойлгоогүй ч Иосефийн хэлсний дагуу, агуулахуудыг үр тариагаар дүүртэл хураажээ.
- Тайлбарлагч** Өнтэй сайхан долоон жил дуусаж, гантай жилүүд эхлэв. Хур бороо ороогүй учир тариан түрүүнүүд хатаж хорчийжээ. Гэсэн ч мэргэн ухаантай Иосеф өнтэй жилүүдэд үр тариаг хураан, хадгалсан учир Египетийн ард түмэнд өлсөх, зовлон ирсэнгүй. Тэр ард түмэнд нөөцөлсөн үр тарианаас хуваан өгч байлаа. Египетэд үр тариа их байгаа тухай холын нутагт ч тархав. Ган зудаас болж Иаковын амьдарч байгаа Канаан нутаг ч өлсгөлөнд нэрвэгдсэн байлаа. Нэгэн өдөр Иаков хөвгүүдээ дуудаж хэлэв.



89 Page



90 Page

- Иосеф** "Египетэд очоод үр тариа худалдаж аваад ир"
- Тайлбарлагч** Арван ах нь бага дүү Бениаминаа гэртээ үлдээгээд, Египет рүү үр тариа авахаар явцгаалаа.
-
- Тайлбарлагч** Египетэд ирээд, ах нар нь Египетийн сайдад хүндэтгэн мэргөв. Тэдний хэн ч Иосеф дүүгээ таньсангүй. Харин Иосеф, ах нараа таньж байлаа. Иосеф багадаа зүүдэлж байсан зүүдээ санав. Тэр, ах нараа хараад уйлах гэсэн боловч биээз барьж, ширүүн дуугаар зэмлэв.
- Иосеф** "Та нар, манай нутгийг тагнахаар ирсэн туршуулууд мөн биз дээ?"
- Ах нар** "Үгүй үгүй, бид үр тариа худалдаж авахаар Канаан нутгаас ирцгээлээ"
- Иосеф** "Та нар ах дүү хэдүүлээ вэ?"
- Ах нар** "Бид бүгд арван хоёулаа, бага дүү маань гэрт байгаа, харин нэг дүү маань алга болсон."
- Тайлбарлагч** Тэдний үгийг сонсоод Иосеф, бага дүү Бениаминыг их санажээ. "Канаанд үлдээсэн дүүгээ дагуулж ирвэл би та нарын үгэнд итгээ"
- Иосеф** "Үр тариагаа аваад буцаад харь. Гэхдээ та нар дундаас нэг хүн нь энд үлдэх хэрэгтэй. Та нар бага дүүгээ авчрахгүй бол үлдсэн хүн нь үхэх болно шүү."



91 Page

Тайлбарлагч Ах нараас нь Симеон тэнд үлдэж бусад нь үр тариагаа аваад Канаан уруу буцжээ.

Тайлбарлагч Иосефийн ах нар бага дүү Бениаминаа дагуулан дахин Египетэд иржээ. Иосеф, дүүгээ хараад маш их баярласан ч ах нараа сорихоор болов. Бениамины үр тария хийсэн уутанд нь нэгэн мөнгөн аягыг нууцаар хийв. Тэгээд мөнгөн аяга хулгайлсан хэргээр гүтгэн Бениаминыг аваад үлдэв. Ах нар нь өвдөг сөгдөн байж, түүнээс гуйв. Хөгшин аав минь Иосеф хүүгээ алдсанаас хойш ихэд гунигласан. Одоо Бениаминыг хүртэл алдчихвал түүнд юу гэж хэлэх билээ" гэцгээлээ.

Ах нар Биднийг учлаач. Хайртай хүүгээ алдсанаа эцэг минь мэдээд үхэх болно. Үнэхээр гүйж байна. Дүүг маань учлаач.

Тайлбарлагч Бага дүүгээ хайрлаж байгаа ах нарын аав болон бие биенээ гэсэн сэтгэлийг хараад Иосеф зеөлрөв.

Тайлбарлагч Иосеф сэтгэлээ барьж чадалгүй ах нараа тэврэн ихэр татан уйлж, тэднийг училжээ.

Иосеф "Ах нар аа би та нарын дүү Иосеф байна."

Ах нар "Үгүй, нээрээ чи Иосеф гэж үү?

Тайлбарлагч Үхсэн гэж бодож байсан дүү нь амьд байгааг хараад, ах нар нь гайхан цочирджээ. Бүр Египетийн сайд болсон дүүгээсээ айн эмээж, чичэрч байлаа. Харин Иосеф ах нараа чин сэтгэлээсээ училжээ.

Иосеф "Бүү санаа зов. Ах нар минь та нар буцан явж аавыг минь авчир, хамтдаа энэ газарт амьдарцгаа."

Тайлбарлагч Ах нарынхаа алдааг училсан Иосеф Египетэд аав, ах дүүтэйгээ хамтдаа аз жаргалтай амьдарчээ.



92 Page